



**“Сэтгэл зүйн дархлааг дэмжье” сарын  
аяны тайлан**

**УЛААНБААТАР ХОТ**

**2021 ОН**

## “Сэтгэл зүйн дархлааг дэмжье” сарын аяны тайлан

Хан уул эрүүл мэндийн төвийн нийт ажилчдын дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх зорилгоор 11-р сарын 15-ны өдрөөс 12-р сарын 15-ны өдөр хүртэл нэг сарын хугацаанд “Сэтгэл зүйн дархлааг дэмжье” сарын аян зохион байгуулсан ажиллаа.

Уг ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа.

1. Эмнэлгийн нийт ажилчдаас ажлын байрнаас халшрах хам шинжийн судалгааг авлаа.

**Зорилго:** Ажилчдын дунд ажлаас халшрах хам шинжийг тодорхойлох

**Зорилт:** Ажилчдын дунд ажлаас халшрах хамшинжийн түвшинг стандарт асуумжийн аргаар тодорхойлох

Судалгааны аргачлал:

Ажлаас халшрах хам шинж нь ажилчидтай холбоотой харилцааны зөрчил, удаан хугацаанд үргэлжилд байгаа таагүй сэтгэл хөдлөл, ажлын байрны бодит нөхцөл, ажлын хэт их ачаалал, ажил үүргийн тодорхой бус байдал, цалин урамшуулал бага байх зэрэг хүчин зүйлүүд удаан хугацаанд үргэлжилсний улмаас үүсдэг. Дэлхий нийтэд “Ажлаас халшрах хамш шинж”-ийг үнэлэхдээ Maslach-ийн асуумжийг зонхилон ашигладаг бөгөөд энэ нь сэтгэцийн хүрээний 3 бүлэг өөрчлөлтөөр авч үздэг. Үүнд:

1. Сэтгэл хөдлөлийн өөрчлөлт / Emotion Exhaustion/ Энэ нь сэтгэцийн талаас ихэвчлэн сэтгэл гутрал болон түгшилтийн хэлбэрээр илэрдэг бол биеийн талаас амархан ядарч сульдах, нойрны өөрчлөлт, толгой өвдөлт зэрэг шинжүүдээр илэрдэг.

2. Өвчтөнийг сэтгэлээрээ мэдрэх чадвар буурах (Depersonalization-Loss of empathy)

3. Хувь хүний ур чадвар (Personal accomplishment)- Энэ ойлголт харьцангуй эерэг үзүүлэлт бөгөөд энэ бүлгийн асуултууд дээр өндөр оноо авах нь ажлаас халшрах хам шинж байхгүй байгааг илтгэдэг. Ажлаас халшрах хам шинжийн үед ажлын бүтээмж буурах, ганцаараа байхыг илүүд үзэх, шалтгаангүй ажлаа таслах, ажилдаа сэтгэл ханамжгүй болох, муу зуршилд автагдах /тамхи, архи, кофег хэтрүүлэн хэрэглэх/, өөрт итгэх итгэлээ алдах зэрэг шинжүүд илэрдэг байна. Байгууллыг ажилчдын ажлаас халшрах хам шинжийг судлан тогтоосноор түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлж, цаашид ажилчдын бие, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг төлөвлөхөд ач холбогдолтой хэмээн үзэж энэхүү сэдвийг сонгосон юм.

Бидний судалгаанд нийт 106 ажилтан хамрагдсан байна. Үүнээс: эмч-46, сувилагч-42, бусад ажилтан-20 тус тус байна.

Нийт:

<b>Ажлаас хамшинжийн үзүүлэлт</b>	<b>халшрах</b>	<b>Бага</b>	<b>Дунд</b>	<b>Өндөр</b>
Сэтгэл хөдлөл буурах		66	25	17
Сэтгэлээр буурах	мэдрэх чадвар	37	26	34
Бүтээмж буурах		39	8	31

Эмч:

<b>Ажлаас хамшинжийн үзүүлэлт</b>	<b>халшрах</b>	<b>Бага</b>	<b>Дунд</b>	<b>Өндөр</b>
Сэтгэл хөдлөл буурах		29	13	5
Сэтгэлээр буурах	мэдрэх чадвар	13	13	16
Бүтээмж буурах		9	21	13

Сувилагч:

<b>Ажлаас хамшинжийн үзүүлэлт</b>	<b>халшрах</b>	<b>Бага</b>	<b>Дунд</b>	<b>Өндөр</b>
Сэтгэл хөдлөл буурах		22	8	10
Сэтгэлээр буурах	мэдрэх чадвар	18	10	12
Бүтээмж буурах		29	3	8

Бусад мэргэжилтэн:

<b>Ажлаас хамшинжийн үзүүлэлт</b>	<b>халшрах</b>	<b>Бага</b>	<b>Дунд</b>	<b>Өндөр</b>
Сэтгэл хөдлөл буурах		19	4	2
Сэтгэлээр буурах	мэдрэх чадвар	16	3	6
Бүтээмж буурах		10	8	7


Дүгнэлт: Судалгаанд хамрагдсан нийт ажилчдын сэтгэл хөдлөл буурах үзүүлэлт 16.3%-д нь өндөр, сэтгэлээр мэдрэх чадвар буурах үзүүлэлт 32%-д өндөр, бүтээмж буурах үзүүлэлт 29.2%-д өндөр үзүүлэлттэй тус тус байна.

Асуумжинд хамрагдсан эмч нарын хувьд ажлын бүтээмж буурах үзүүлэлт харьцангуй өндөр буюу 28.3%-тай байна. Сувилагч нарын хувьд сэтгэлээр мэдрэх чадвар буурах үзүүлэлт 28.5%-тай байна. Бусад эмнэлгийн мэргэжилтэн нарын хувьд бага үзүүлэлттэй тус тус гарсан байна. Судалгаанаас харахад ажлын бүтээмж буурах, сэтгэлээр мэдрэх чадвар буурах үзүүлэлт эмч, сувилагч нарын дунд өндөр гарч байгаа тул ажилчдын дунд сэтгэл зүйн сургалт, сурталчилгаа, эерэг уур амьсгал бүрдүүлэх ажил үе шаттайгаар зохион байгуулах хэрэгцээ шаардлагатай байгааг харуулж байна.



2. Хүний нөөцийн албанаас 2021 оны ажлын дүгнэлт болон шинэ ажилчдыг танилцуулах, аяны үйл ажиллагааг сурталчилан танилцуулах зорилгоор эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан нарт нийт 3 удаагийн уулзалт сургалтыг зохион байгууллаа.




3. Дууг үргэлжүүл контентыг бүх тасаг нэгжүүдийн дунд зохион байгуулж байгууллагын дотоод группт байршуулж байлаа.



4. Төрсөн өдөр нь тохиож буй ажилтан нарт мэндчилгээг бэлтгэн байгууллагын дотоод группт байршуулж ажиллаа.




5. Мөн байгууллагын дотоод группт өдөр бүр ажилчдад урам өгөх, эерэг мэдээлэл байршуулж байлаа.



Erdenebileg Purevsuren and 23 others 1 Comment

Like Comment Send

Write a comment...



20 1 Comment • Seen by

Like Comment Send

Write a comment...

Өлзий-Орших Ариунжаргал 23 Nov

6. Ажлын бус цагаар бүжгийн багштай хамтран өдөр бүр 1 цаг бүжгийн хичээл оруулсан. Тасаг нэгжүүд идэвхтэй хамрагдлаа.




"Сэтгэл зүйн дархлаагаа дэмжье" аяны хүрээнд Яармаг салбарын хамт олон бүжгийн хичээлдээ идэвхитэй хамрагдаж 1 өдрийн 1 цагийг хөгжилтэй, хөдөлгөөнтэй өнгөрүүллээ (группын хуралтай өдөр байсан учир зарим нь төв салбар яваад оролцож амжаагүй болно) Идэвхитэй оролцсон хамт олондоо б...



35 9 comments • Seen by

Love Comment Send

Write a comment...



Манайхаан бүжгэндээ идэвхитэй оролцоорой



45 11 comments • Seen by

Love Comment Send

Write a comment...

7. Бүх тасаг нэгжүүдийн дунд Дартс болон Волейболын тэмцээн зохион байгууллаа. Уг тэмцээнд Волейбол 1-р байр Поликлиникийн баг, 2-р байр Хэвтэн эмчлүүлэх тасгийн баг, 3-р байр Яармаг салбар амбулаторын баг тус тус эзэлсэн. Дартс эрэгтэй Захиргаа аж ахуйн тасаг, эмэгтэй Яармаг салбар амбулаторын тасаг тус тус эзэлсэн байна.



8. Чила Лектортай хамтран “Амьдралын үнэ цэнэ” сургалтыг зохион байгууллаа.



ХЯНАСАН:  
ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА:  
БОЛОВСРУУЛСАН: НАРИЙН БИЧИГ:

Ц.ЭНХБАЯСАГЛАН  
Г.БҮЖИДМАА

